

ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төслийн тухай

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох”-оор, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн 3.1-д Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрдэнэсийн сангийн эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор тус тус заасны дагуу Эрдэнэсийн сангийн эрх зүйн зохицуулалтыг практик шаардлага болон бусад хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлттэй нийцүүлэх, эрдэнэсийн тодорхойлолтыг Монгол Улсын онцлог, дэлхий нийтийн жишигт тохируулан шинэчлэх, үүнтэй холбоотойгоор Эрдэнэсийн сангийн шилжилт хөдөлгөөний зарцуулалт, Монголбанкнаас эрдэнэсийн сангийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг боловсронгуй болгох шаардлага, зорилгоор Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Эрдэнэсийн санд холбогдох харилцааг Эрдэнэсийн сангийн тухай хууль, Монголбанкны журмаар зохицуулж байна. Эрдэнэсийн сангийн тухай хууль 1994 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсанаас хойш тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн өөрчлөлтөөр нэр томъёоны тодорхойлолт нэмсэн, гүйлгээний сангийн зориулалт, Улсын Их Хурлын бүрэн эрх, гадаад валютын улсын нөөц, Эрдэнэсийн сангийн бүртгэлтэй холбоотой өөрчлөлт оруулсанаас өөр зарчмын томоохон шинэчлэл хийгдээгүй байна.

Хуулийн төсөл нь Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, уг харилцаанд төрийн байгууллагын эдлэх бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн оролцоог тодорхойлж, зохицуулсан нийт 6 бүлэг, 18 зүйлтэй болно. Хуулийн төслөөр эрдэнэсийн санд холбогдох нэр томъёог холбогдох олон улсын стандарт, Монгол Улсын бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсоноос гадна гүйлгээ сангийн зарцуулалт, эрдэнэсийн сангийн бүртгэл, Эрдэнэсийн санд олборлосон алт авах, гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэх үйл ажиллагаа, иргэн, хуулийн этгээд эрдэнэс эзэмших, Монголбанк үнэт металлын сорьц тогтоох үйл ажиллагаа явуулах зэрэг зохицуулалтыг тусгасан болно.

Олон улсын туршлагаар алтны сорьц тогтоох үйл ажиллагааг тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага гүйцэтгэхээс гадна төв банк, тусгай зөвшөөрөлтэй хувийн хөрөнгө оруулалт бүхий бусад хуулийн этгээд эрхэлж байна. Хуулийн төслийг дагалдан өөрчлөлт орох Ашигт малтмалын тухай хуульд Монголбанкинд тушаах үнэт металлын сорьцыг сорьц тогтоох төрийн захиргааны байгууллагаас гадна, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, эсхүл Монголбанк тогтоож болох зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулахдаа Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яам, Соёлын өвийн

төв, сэтгүүлч, олон нийттэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрийн саналыг тусгах арга хэмжээ авсан болно.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Монгол Улсын түүх, соёлын өвийн эрх зүйн хамгаалалт сайжирч, үнэ цэнэ нэмэгдэх, эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагаа өргөжиж боловсронгуй болох, иргэд, хуулийн этгээд худалдах үнэт металын олон улсын стандартад нийцсэн сорьцыг тогтоолгох, улмаар үнэт металлын эдийн засгийн эргэлт сайжрах зэрэг нийгэм, эдийн засаг, эрх зүйн эерэг үр дагавар бий болно.

_____оОо_____